

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ: ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

ТОЙМ ДҮГНЭЛТ

Боловсруулсан:

Д. Баярмаа (ШУТИС-БухС-ийн багш, докторант)

Хянан тохиолдуулсан: Д. Оюунбадам

2016 оны 11-р сар

Энэхүү тойм дүгнэлт нь Нээлттэй Нийгмийн Форумын албан ёсны байр суурь биш бөгөөд зөвхөн хувь судлаачийн байр суурийг илтгэнэ.

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	1
НЭГ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БА ТОДОТГОЛ.....	2
ХОЁР. НЭГДСЭН ТӨСВИЙН 2010-2017 ОНЫ ЗАРЛАГЫН ЧИГ ХАНДЛАГА....	5
ГУРАВ. 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ.....	7
ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНД БА БСШУС-ЫН САЙДЫН 2012-2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА.....	15
ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
ЗУРГАА. БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
ДОЛОО. ТОЙМ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ.....	30

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ASEM	–	Ази Европын дээд хэмжээний уулзалт
БСПШУС	–	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
ДНБ	–	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	–	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	–	Засгийн газар
МУ	–	Монгол Улс
НДШ	–	Нийгмийн даатгалын шимтгэл
ННФ	–	Нээлттэй нийгэм форум
УБ	–	Улаанбаатар
УЗ	–	Урсгал зардал
ХЗ	–	Хөрөнгийн зардал
ҮАГ	–	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	–	Үндэсний Статистикийн Хороо
ЭТЦЗ	–	Эргэж төлөгдөх цэвэр зээл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	2017 оны нэгдсэн төсөв дэх өндөр өсөлттэй зардлын зарим төрлүүд	10
Хүснэгт 2.	2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (тойм)	13
Хүснэгт 3.	2017 онд Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)	13
Хүснэгт 4.	2017 онд Концессын гэрээгээр санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)	13
Хүснэгт 5.	Хөдөө орон нутаг ба хот дахь эмнэлгийн ор ба мэргэжилтний хүртээмж	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар	2
Зураг 2.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар (салбараар)	3
Зураг 3.	Эрүүл мэнд ба боловсролын салбарын хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар	3
Зураг 4.	2016 оны 9-р сард хийсэн нэгдсэн төсвийн зарлагын тодотгол	4
Зураг 5.	2010-2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	5
Зураг 6.	2010-2017 оны нэгдсэн төсвийн урсгал зардал	6
Зураг 7.	2010-2017 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал	6
Зураг 8.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зарцуулалт (эзлэх хувийн жин)	7
Зураг 9.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зардлын өсөлт, бууралт (2016 оны тодотгосон төсөвтэй харьцуулсан)	8
Зураг 10.	2017 оны нэгдсэн төсвийн урсгал зарлага	9
Зураг 11.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн урсгал зардлын төлөвлөгөө (эзлэх хувийн жин)	10
Зураг 12.	2017 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал	11
Зураг 13.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хөрөнгийн зардлын төлөвлөгөө (эзлэх хувийн жин)	12
Зураг 14.	2017 оны хөрөнгө оруулалт	12
Зураг 15.	Эрүүл мэндийн сайдын 2012-2017 оны төсвийн зарцуулалт	15
Зураг 16.	БСШУС-ын сайдын 2012-2017 оны төсвийн зарцуулалт	16
Зураг 17.	Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалт (1 хүн амд ноогдох)	16
Зураг 18.	Эрүүл мэнд, боловсролын салбарын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь	17
Зураг 19.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны багцын эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн урсгал зардал	18
Зураг 20.	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)	19
Зураг 21.	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	20
Зураг 22.	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	20
Зураг 23.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	21
Зураг 24.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд (аймаг, хот)	21
Зураг 25.	Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)	22
Зураг 26.	Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	22
Зураг 27.	БСШУС-ын сайдын 2017 оны багцын Боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрүүдийн урсгал зардал	24
Зураг 28.	Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	25
Зураг 29.	Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	26
Зураг 30.	Дээд боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)	27
Зураг 31.	Дээд боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	27
Зураг 32.	Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)	28
Зураг 33.	Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд	28
Зураг 34.	Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)	29

ХУРААНГУЙ

Нээлттэй Нийгэм Форумгаас жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тойм шинжилгээ хийж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, хэвлэл мэдээллийнхэн, иргэд, олон нийтэд танилцуулдаг.

Нээлттэй Нийгэм Форумтай байгуулсан гэрээний дагуу судлаач Монгол Улсын 2017 оны Нэгдсэн төсвийн төслийн зарлагын төлөвлөлтөд хийсэн тойм дүгнэлтийг 2016 оны 10-11-р сард боловсруулсан болно.

Судлаачийн боловсруулсан тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтсан. Үүнд:

- Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл ба тодотгол
- Монгол Улсын 2012-2017 оны нэгдсэн төсвийн зарлагын чиг хандлага
- Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээ
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны төсвийн зарцуулалтын төлөвлөгөө
- БСШУС-ын сайдын 2017 оны төсвийн зарцуулалтын төлөвлөгөө

Тайлангийн үндсэн зорилго нь төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий байдлаар богино хугацаанд танилцуулж, төсвийн төсөлд хараат бус, хөндлөнгийн дүгнэлт өгөхөд оршино.


Энэхүү танилцуулгыг боловсруулахдаа Сангийн яамны төсвийн мэдээллүүд, Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо, Эрүүл мэндийн яам, БСШУС-ын яам, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын судалгааны байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлав.

НЭГ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БА ТОДОТГОЛ

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 2016 оны 9-р сарын байдлаар 81.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2016 оны 9 дүгээр сарын байдлаар 7.41 их наяд төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6.06 их наяд төгрөгийн буюу 81.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Зардлын төрөл тус бүрээр авч үзвэл цалин хөлс, НДШ-ийн зардал 97.1%, бараа үйлчилгээний бусад зардал 83.18%, хүүгийн зардал 74.6%, татаас 83.5%, урсгал шилжүүлэг 92.47%-ийн гүйцэтгэлтэй буюу нийт урсгал зардлын гүйцэтгэл 89.1% байгаа бол хөрөнгийн зардлын гүйцэтгэл 58.4% байна.

Зураг 1. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 9-р сарын байдлаарх гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал өндөр өсөлттэй байна.


Харин нэгдсэн төсвийн нийт зарлагын эхний 9 сарын гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулбал нийт 1.15 их наяд төгрөг буюу 23.4%-иар өссөн гүйцэтгэлтэй гарсан нь 2016 онд нийт зарлагын тэлэлт өндөр байсныг харуулж байна. Үүнд, бараа, ажил үйлчилгээний зардал 6.2%, зээлийн үйлчилгээний төлбөр 31.2%, татаас ба урсгал шилжүүлэг 11.5%, хөрөнгийн зардал 8.3%-иар өссөн нь нөлөөлжээ. Сангийн яамны зүгээс нийт зарлагын өсөлтийг Олон улсын арбитрын шүүхийн шийдвэрийн дагуу Канадын Хан ресурс компанид Засгийн газраас олгох нөхөн төлбөрийн зардал, УИХ-ын ээлжит сонгууль, Ази Европын дээд хэмжээний уулзалт (ASEM), зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт, хүн амын дундаж насжилт нэмэгдсэнээс шалтгаалсан тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт, өмнөх оны 12-р сарын Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн санхүүжилтийг 2016 онд санхүүжүүлсэн зэрэг шалтгаантай холбон тайлбарласан байна.

2016 оны 9-р сарын байдлаар эрүүл мэндийн салбарын зардлын гүйцэтгэл 92.4%, боловсролын салбарын гүйцэтгэл 81%-тай байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг салбараар авч үзвэл тээвэр холбооны салбарын гүйцэтгэл хэтэрч 174.4%-д хүрсэн бол эрчим хүч, дулаан хангамжийн салбарын гүйцэтгэл хамгийн бага буюу 29.5%-тай байна. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэл 92.4%, боловсролын салбарын гүйцэтгэл 81%-тай байна.

Зураг 2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар (салбараар)


Гүйцэтгэл хувь %



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн дүн шинжилгээ

Харин эрүүл мэнд, боловсролын хөтөлбөрөөр авч үзвэл эрүүл мэндийн хөтөлбөр 89.6%, боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөр 84.4%-ийн гүйцэтгэлтэй байна. Арга хэмжээгээр авч үзвэл эрүүл мэндийн арга хэмжээ 66.8%, боловсролын арга хэмжээ 86%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 3. Эрүүл мэнд ба боловсролын салбарын хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл 2016 оны 9-р сарын байдлаар



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Их хэмжээний тодотгол нь төсвийн зардалд тавих хяналт маш сул байгааг харуулж байна.

2016 оны төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт зардал 1740.0 тэрбум төгрөг буюу 21.9 хувиар, үүнээс урсгал зардал 494.1 тэрбум төгрөг буюу 7.9 хувиар, хөрөнгийн зардал 419.6 тэрбум төгрөг буюу 21.7 хувиар, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 826.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Төсөвт их хэмжээгээр тодотгол хийсэн нь сонгуулийн жил, валютын ханшийн өсөлт, өрийн үйлчилгээ, төсөвт тусгагдаагүй арга хэмжээнүүд хэрэгжүүлсэн зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой гэж дүгнэж байна. Төсвийн тодотголоор нэмэгдсэн зардлуудын 52.6% нь УИХ болон ЗГ-ын шийдвэрээр хэрэгжүүлж эхэлсэн нэг удаагийн шинжтэй төсөл, арга хэмжээний зардал, 17.2% нь УИХ болон ЗГ-ын шийдвэрээр шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний зардал, 18.8% нь гадаадын зээл, ЗГ-ын тусгай сангийн орлого, эх үүсвэрээс санхүүжих арга хэмжээний зардал, 11.4% нь төсвийн гүйцэтгэлээс буюу санхүүжүүлэх эх үүсвэр нэмж дайчилснаас шалтгаалах зээлийн хүү, валютын ханшний өөрчлөлтөөр нэмэгдэх зардал байна. Тодотголоор нэмэгдсэн зардлуудыг зардлын ангиллаар нарийвчлан авч үзвэл хамгийн өндөр хувь буюу 31.2%-ийг “Сайн хөтөлбөрүүд”-ийн зардал, 15.2%-ийг гадаад зээлийн ашиглалтаар нэмэгдэх зардал эзэлж байна. Жил бүр төсөвт их хэмжээний тодотгол хийж байгаа нь төсвийн зардалд тавих хяналт маш сул байгааг харуулж байна.

Зураг 4. 2016 оны 9-р сард хийсэн нэгдсэн төсвийн зарлагын тодотгол




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

ХОЁР. НЭГДСЭН ТӨСВИЙН 2010-2017 ОНЫ ЗАРЛАГЫН ЧИГ ХАНДЛАГА

2010-2017 онд урсгал зардлын хэмжээ жилд дунджаар 14.1%-иар өсчээ.

2010-2017 оны чиг хандлагаар нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн жилийн дундаж өсөлт 14.1% байна. Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувийн жин 2016 онд өмнөх онуудтай харьцуулахад эрс өсч 40.1%-д хүрсэн байна. Нийт зарлага ба цэвэр зээлийг бүтцээр нь авч үзвэл урсгал зардлын эзлэх хувийн жин нэмэгдэж байна.

Зураг 5. 2010-2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл



2010-2017 оны нэгдсэн төсвийн нийт зардлын бүтэц (%)


	2010	2011	2012	2013	2014	2015	2016 төл	2016 тод	2017 төс
УЗ	73.3%	64.8%	73.6%	73.8%	74.1%	80.1%	78.2%	69.3%	81.0%
ХЗ	19.2%	25.6%	25.3%	24.2%	24.8%	19.6%	24.3%	24.2%	17.4%
ЭТЦЗ	7.6%	9.6%	1.1%	2.0%	1.1%	0.3%	-2.5%	6.5%	1.5%

Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2010-2017 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын чиг хандлагыг авч үзвэл зээлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ хамгийн өндөр өсөлттэй байна.

2010-2017 оны урсгал зардлын төрөл тус бүрээр зардлын чиг хандлагыг авч үзвэл цалин хөлс, НДШ-ийн зардлын жилийн дундаж өсөлт 14.1%, бараа үйлчилгээний зардлын жилийн дундаж өсөлт 13%, татаас ба урсгал шилжүүлгийн зардлын жилийн дундаж өсөлт 12.7%, зээлийн үйлчилгээний төлбөрийн жилийн дундаж өсөлт хамгийн өндөр буюу 49.5%-тай байна. Эдийн засаг, уул уурхайн салбарын өсөлттэй жилүүдэд нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээг орлогын өсөлттэй холбоотой нэмэгдүүлж ирсэн бөгөөд эдийн засаг, төсвийн хүндрэлтэй цаг үед орлогын бууралттай холбоотой төсвийн зардлыг хязгаарлах бодлого барьж байгаа ч цалин хөлс, нийгмийн халамжийн зардлууд, зээлийн үйлчилгээний төлбөр гэх мэт зохицуулах боломж муутай урсгал зардлын төрлүүдийг богино хугацаанд бууруулж, хязгаарлах боломж бага байна. Иймд цаашид нэгдсэн төсвийн урсгал зардлын шийдвэрийг төсвийн орлогын өсөлтөөс ангид байлгах шаардлагатай.

Зураг 6. 2010-2017 оны нэгдсэн төсвийн урсгал зардал



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Барилга, байгууламж, засварын зардал сүүлийн жилүүдэд буурчээ.

2010-2017 оны хөрөнгийн зардлын төрөл тус бүрээр зардлын чиг хандлагыг авч үзвэл барилга, байгууламжийн зардлын жилийн дундаж өсөлт 2.9%, тоног төхөөрөмжийн зардлын жилийн дундаж өсөлт 10.8%, их засварын зардлын жилийн дундаж өсөлт 8.8%, стратегийн нөөц хөрөнгө жилийн дундаж өсөлт 21.9% байгаа бол 2015 оноос нэгдсэн төсөвт оруулж тооцох болсон төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ жилд дунджаар 46%-иар буурсан үзүүлэлттэй байна. Их засварын зардлын хэмжээг 2016 оноос эхлэн их хэмжээгээр бууруулсан¹.

Зураг 7. 2010-2017 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

¹ Төсвийн засвар, үйлчилгээний зардал буурах нь хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үйл ажиллагааг хэвийн хангах, зохих үр ашгийг хүртэхэд сөргөөр нөлөөлнө” (Дэлхийн банк, “Дэд бүтцийн судалгаа” тайлан)

ГУРАВ. 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

2017 оны нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг өмнөх оны тодотгосон түвшнээс бууруулж тооцсон боловч 2015 оны гүйцэтгэл ба 2016 оны эхний төсөвтэй харьцуулахад өссөн дүнтэй байна.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 8.56 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд өмнөх оны тодотголоор батлагдсан түвшнээс 1130.4 тэрбум төгрөг буюу 13.2%-иар буурсан байна. Гэвч 2015 оны нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэлтэй харьцуулахад 19.9%-иар, 2016 оны батлагдсан эхний төсөвтэй харьцуулахад 7.6%-иар өссөн дүнтэй байна.

2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь 32.7%-тай тэнцүү байхаар төсөвлөжээ. Нийт зарлагын 81.0% буюу 6.94 их наяд төгрөгийг урсгал зардалд, 17.4% буюу 1.49 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд төсөвлөсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зарлагыг эзлэх хувийн жингээр нь эрэмбэлэн авч үзвэл Сангийн сайд 25.44%, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 20.67%, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 16.15%, Эрүүл мэндийн сайд 9.94%, Хууль зүй, дотоод хэргийн сайд 6.28%, Зам, тээврийн хөгжлийн сайд 4.53%, Батлан хамгаалахын сайд 3.06%, Монгол улсын ерөнхий сайд 3.03%, бусад сайд нарт 10.9% ноогдож байна.

Зураг 8. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зарлага (эзлэх хувийн жин)




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зардлагыг 2016 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад МУ-ын үндсэн хуулийн цэцийн дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, МУ-ын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга нарын төсвийн

зарцуулалт өндөр өсөлттэй байгаа бол Зам тээврийн хөгжлийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Гадаад харилцааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарын төсвийн зарцуулалт буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн нийт зарлагын өсөлт, бууралт (2016 оны тодотгосон төсөвтэй харьцуулсан)

Өөрчлөлт (%)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


Урсгал зардлын өсөлтөд зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт голлон нөлөөлж байгаа бөгөөд бараа үйлчилгээний зардлыг бууруулах замаар урсгал зардлын өсөлтийг хязгаарлахаар төлөвлөжээ.

2017 оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагыг 6.94 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшнээс 220.5 тэрбум төгрөгөөр их буюу 3.28%-ийн өсөлттэй байна. Харин 2016 оны эхний батлагдсан төсөвтэй харьцуулахад 11.48%-иар өсчээ. Энэ нь урсгал зарлагын тэлэлт үргэлжилсээр байгааг харуулж байна. Нийт зарлага ба цэвэр зээлд урсгал зардлын эзлэх хувийн жин 81.0% байна. Урсгал зарлагыг зардлын төрөл тус бүрээр өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад цалин хөлс 1.87%, зээлийн үйлчилгээний төлбөр 29.22%, урсгал шилжүүлэг 2.08%-иар тус тус өсч, бараа үйлчилгээний зардал 10.79%, татаас 5.22%-иар тус тус буурчээ. Харин 2016 оны эхний төсөвтэй харьцуулахад урсгал зардлын төрөл тус бүр өссөн байна. ҮСХ-оос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар хүн амын насжилт нэмэгдэж, нийт хүн ам дахь

тэтгэвэрийн насны хүн амын тоо нэмэгдэж байгаа нь төсвийн урсгал зарлагын дарамтыг улам нэмэгдүүлэхээр байна.

Нийт урсгал зарлагыг бүтцээр нь авч үзвэл цалин хөлс 25.1%, бараа үйлчилгээний бусад зардал 18.5%, зээлийн үйлчилгээний зардал 19.5%, татаас 2.8%, урсгал шилжүүлэг 34.1%-ийг эзэлж байна. Төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимоор ажиллах, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн түвшинг хадгалах, зээлийн хүүгийн зардлын өсөлтийг хязгаарлах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах зарчим баримтална гэж төлөвлөжээ.

Зураг 10. 2017 оны нэгдсэн төсвийн урсгал зарлага



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Нэгдсэн төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлах зарчимтай үл нийцэх, 2015 оны гүйцэтгэл ба 2016 эхний төсөвтэй харьцуулахад өндөр өсөлттэй урсгал зардлуудыг дахин хянаж үзэх шаардлагатай.

2017 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын өөрчлөлтийг зардлын төрөл тус бүрээр 2015 оны гүйцэтгэл ба 2016 оны эхний батлагдсан төсөвтэй харьцуулахад зардлын зарим төрлүүд өндөр өсөлттэй байна. Тухайлбал, нэмэгдэл цалин, тэтгэмжийн даатгал, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, мэдээллийн технологийн үйлчилгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэгийн зардлууд өндөр өсөлттэй байгаа нь 2017 оны төсвийн урсгал зардлын


өсөлтийг хязгаарлах зарчимтай үл нийцэж байгаа тул дахин хянаж үзэх шаардлагатай байна.

Хүснэгт 1. 2017 оны нэгдсэн төсөв дэх өндөр өсөлттэй зардлын зарим төрлүүд (2015 оны гүйцэтгэл ба 2016 оны батлагдсан эхний төсөвтэй харьцуулсан)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	Өсөлт %	
	2015 оны гүйцэтгэлтэй харьцуулсан	2016 оны эхний төсөвтэй харьцуулсан
Нэмэгдэл цалин	362.8%	245.9%
Тэтгэмжийн даатгал	57.5%	22.4%
Ном хэвлэл	22.8%	147%
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	173.5%	47.7%
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж	-	464.5%
Мэдээллийн технологийн үйлчилгээ	41.3%	28.4%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22.1%	30.8%
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг	19%	48%

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн урсгал зарлагыг эзлэх хувийн жингээр нь эрэмбэлэн авч үзвэл Сангийн сайд 30.3%, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд 19.3%, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 18.3%, Эрүүл мэндийн сайд 10.5%, Хууль зүй, дотоод хэргийн сайд 7.4%, Батлан хамгаалахын сайд 3.6%, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 1.7%, Монгол улсын шадар сайд 1.7%, бусад сайд нарт 7.1% ноогдож байна.

Зураг 11. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн урсгал зарлага (эзлэх хувийн жин)




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Нийт зардлын өсөлтийг хязгаарлах зорилтыг хөрөнгийн зардлыг бууруулах замаар шийдвэрлэхийг оролдож байна. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зардал, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалтыг бууруулж төлөвлөжээ.

2017 оны нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардлыг 1.49 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд өмнөх оны тодотголоор батлагдсан түвшнээс 855.9 тэрбум төгрөгөөр буюу 36.42%-иар буурчээ. Харин 2016 оны эхний төсөвтэй харьцуулахад 22.6%-иар буурсан байна. Нийт зарлага ба цэвэр зээлд хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин 17.4% байна.

Хөрөнгийн зардлыг төрөл тус бүрээр нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад их засварын зардал 25.94%, стратегийн нөөц хөрөнгө 100.6%-иар тус тус өсч, барилга байгууламжийн зардал 53.12%, тоног төхөөрөмжийн зардал 39.42%, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 44.54%-иар тус тус буурчээ. Хөрөнгө оруулалтын шинэ арга хэмжээ эхлүүлэхгүй байх, өмнөх онуудад эхэлсэн дуусаагүй ажлуудыг гүйцээх, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбарын зайлшгүй хөрөнгө оруулалтыг заавал тусгах зарчим баримтлахаар төлөвлөжээ.


Зураг 12. 2017 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хөрөнгийн зарлагыг эзлэх хувийн жингээр нь эрэмбэлэн авч үзвэл Монгол Улсын ерөнхий сайд 27.5%, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд 23.1%, Эрүүл мэндийн сайд 8.2%, Зам тээврийн хөгжлийн сайд 7.0%, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 6.8%, Хууль зүй, дотоод хэргийн сайд 6.5%, Эрчим хүчний сайд 6.3%, Барилга, хот байгуулалтын сайд 4.0%, бусад сайд нарт 10.6% ноогдож байна.

Зураг 13. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны төсвийн хөрөнгийн зарлага (эзлэх хувийн жин)




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2017 онд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 59.7%-иар буурна.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Улсын төсөв, Хөгжлийн банк, Концесс, Векселийн хөрөнгө оруулалтуудыг нэгтгэн нэгдсэн төсөвтэй болсон. 2017 онд нийт 547.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн бөгөөд энэ нь 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 59.7%-иар буурсан үзүүлэлт юм. Нийт хөрөнгө оруулалтын 47.3%-ийг улсын төсвөөс, 31.6%-ийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэрээр, 21.1%-ийг концессийн гэрээгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Зураг 14. 2017 оны хөрөнгө оруулалт



Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд 182 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг нийт 259.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Эдгээрийн 87.1%-ийг шилжих, 12.9%-ийг шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Хүснэгт 2. 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (тойм)

ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2006 онд 1 төсөл, 2008 онд 3 төсөл, 2009 онд 1 төсөл, 2010 онд 10 төсөл, 2011 онд 19 төсөл, 2012 онд 48 төсөл, 2013 онд 38 төсөл, 2014 онд 21 төсөл, 2015 онд 12 төсөл, 2016 онд 23 төсөл тус тус хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2017 онд 6 төсөл шинээр хэрэгжиж эхэлнэ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 123 төсөл, 2018 онд 47 төсөл, 2019 онд 9 төсөл, 2020 онд 3 төсөл хэрэгжиж дуусна.
ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Нэгдсэн хорих анги, инженерийн байгууламж, 1500 хүн /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, 12.1 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн Монголын талын хөрөнгө /Орхон, Баян-Өндөр сум/, 10.8 сая төгрөг

2017 онд Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 119 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 172.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Эдгээр нь бүгд шилжих төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 3. 2017 онд Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)

ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2011 онд 2 төсөл, 2012 онд 7 төсөл, 2013 онд 20 төсөл, 2014 онд 73 төсөл, 2015 онд 12 төсөл, 2016 онд 5 төсөл тус тус хэрэгжиж эхэлжээ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 109 төсөл, 2018 онд 10 төсөл хэрэгжиж дуусна.
ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ Засгийн газрын 2015 оны 313 тоот тогтоолын хүрээнд хийгдэх авто зам, /Төв, Хөшигийн хөндий/, 17.3 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянган тростой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил, 5.7 сая төгрөг

“Барих-шилжүүлэх” концессын төрлөөр 2017 онд 15 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг нийт 115.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Эдгээр нь бүгд шилжих төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 5. 2017 онд Концессын гэрээгээр санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)

ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2014 онд 1 төсөл, 2015 онд 6 төсөл, 2016 онд 8 төсөл тус тус хэрэгжиж эхэлжээ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 8 төсөл, 2018 онд 5 төсөл, 2019 онд 2 төсөл хэрэгжиж дуусна.
ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл, 28.5 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/, 0.8 тэрбум төгрөг


Үндэсний Аудитын Газраас “Шилжих төслүүдээс хуулийн шаардлага хангаагүй гэрээний зөрчил бүхий нийт 7.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл арга хэмжээг 2017 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгах шаардлагагүй байна. Шинээр эхлүүлэхээр тусгасан нийт 33.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 6 төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил тодорхойгүй, хэт ерөнхий тогтоосон, нотлох баримт, үндэслэл тооцоолол байхгүй зэрэг нь холбогдох хуулийн шаардлагыг хангахгүй байна. Мөн Концессын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээнд зааснаас илүү санхүүжилт олгохоор төлөвлөсөн 2 төсөл, арга хэмжээг хасах нь зүйтэй” гэж дүгнэжээ.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БА БСШУС-ЫН САЙДЫН 2010-2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байгаа бол боловсролын салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь бусад орнуудтай ойролцоо түвшинд байна.

2012-2017 оны чиг хандлагаар эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтын жилийн дундаж өсөлт 8.6% байна. 2012-2016 онд Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагын нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувийн жин 6.7-8.7%, ДНБ-д эзлэх хувийн жин 2.4-3.1%-ийн хооронд хэлбэлзэж байжээ. 2017 онд Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагын нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувийн жин 7.6% , ДНБ-д эзлэх хувийн жин 2.8% байхаар төсөвлөжээ.


Зураг 15. Эрүүл мэндийн сайдын 2012-2017 оны төсвийн зарлага



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


2012-2017 оны чиг хандлагаар БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын жилийн дундаж өсөлт 8.3% байна. 2012-2016 онд БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувийн жин 13.8-16.9%-ийн хооронд, ДНБ-д эзлэх хувийн жин 5.0-6.1%-ийн хооронд хэлбэлзэж байжээ. 2017 онд БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувийн жин 15.9% , ДНБ-д эзлэх хувийн жин 5.7% байхаар төсөвлөжээ.

Зураг 16. БСШУС-ын сайдын 2012-2017 оны төсвийн зарлага



2012-2017 оны чиг хандлагаар нэг хүн амд ноогдох Эрүүл мэндийн сайд ба БСШУС-ын сайдын төсвийн зарлагыг тооцвол өсөлтийн хурд харьцангуй бага байна. 2012-2017 онд нэг хүн амд ногдох Эрүүл мэндийн сайдын төсвийн нийт зарлагын жилийн дундаж өсөлт 6.3%, БСШУС-ын сайдын төсвийн зарлагын жилийн дундаж өсөлт 6.6% байна.


Зураг 17. Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын төсвийн зарлага (1 хүн амд ноогдох)



Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг Дэлхийн банкны ангилал ба тооцоогоор авч үзвэл өндөр орлоготой орнуудад 12.3 хувь, дунджаас дээгүүр орлоготой орнуудад 6.2 хувь, дунджаас доогуур орлоготой орнуудад 4.5 хувь, бага орлоготой орнуудад 5.7 хувь байна. Монгол орны хувьд дунджаас доогуур орлоготой орны тоонд багтаж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2.9 хувь байгаа нь бусад улс орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байна.

Боловсролын салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь өндөр орлоготой орнуудад 4.8 хувь, дунджаас дээгүүр орлоготой орнуудад 4.2 хувь, дунджаас доогуур орлоготой ба бага орлоготой орнуудад 4.1 хувь байна. Монгол орны хувьд боловсролын салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 4.1 хувьтай байгаа нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад ойролцоо түвшинд байна.

Зураг 18. Эрүүл мэнд, боловсролын салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь



*2015 оны үзүүлэлтийг харьцуулав. Дэлхийн банкны ангиллаар Монгол улс дунджаас доогуур орлоготой орны тоонд багтаж байна.

Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн банк

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


2017 онд эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд зарцуулах нийт урсгал зардлын хэмжээ өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад бага зэрэг өснө.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсөвт Эрүүл мэндийн сайдын багц дахь эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн нийт урсгал зардлын хэмжээг 573.5 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад 5.3%-иар өсчээ.

Үүнээс нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд 9.9%, эмнэлэгийн тусламж үйлчилгээнд 82.1%, эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрт 8.1%-ийг тус тус зарцуулна. Өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн урсгал зардал 11.9%-иар, эмнэлэгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн урсгал зардал 3.4%-иар, эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн урсгал зардал 18.8%-иар тус тус өсчээ.

Нийт эрүүл мэндийн хөтөлбөрийн урсгал зардлыг төрлөөр нь авч үзвэл цалин, НДШ 41.5%, бараа үйлчилгээ 33.9%, татаас шилжүүлэг 24.6%-ийг тус тус эзэлж байна. Нийт эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн урсгал зардлын 30.8%-ийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

Зураг 19. Эрүүл мэндийн сайдын 2017 оны багцын эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн урсгал зардал



Сүүлийн жилүүдэд нийгмийн эрүүл мэндийн үр дүнгийн үзүүлэлтүүдэд төдийлөн өндөр ахиц гараагүй байна.

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл эрүүл мэндийг дэмжих, үндсэн үйл ажиллагааны, харуул хамгаалалтын, анхан шатны тусламж үйлчилгээний тусгай шилжүүлгийн зардал тус тус өссөн бол ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь анхан шатны тусламж үйлчилгээний зардал 49%, үндсэн үйл ажиллагааны зардал 41% байна.

Зураг 20. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Сүүлийн жилүүдэд нийгмийн эрүүл мэндийн үр дүнгийн үзүүлэлтүүдэд төдийлөн өндөр ахиц гараагүй байна. Тухайлбал, 2015 онд түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлт 77.6%-тай байгаа нь 2014 онтой харьцуулахад 1.2%-иар өссөн үзүүлэлт боловч шинэ халдвартай сүрьеэгийн өвчтөний эмчилгээний амжилт 84.3%, эдгэрэлт 79.5% байгаа нь 2014 оныхоос эмчилгээний амжилт 0.8%, эдгэрэлт 1.2%-иар тус тус буурсан байна.

2015 оны эцсийн байдлаар хорт хавдрын улмаас эмчийн хяналтад байгаа нийт 15036 өвчтөн байгаагаас 5-аас дээш жил амьдарч байгаа хүмүүс 31.7%-ийг эзэлж 2014 онтой харьцуулахад 2.8%-иар өссөн боловч 2013 онтой харьцуулахад 1.4%-иар буурсан байна.

100000 хүн амд ноогдох сүрьеэгийн шалтгаант нас баралтын түвшин 2-оос доош буухгүй байна. 0-1 хүртлэх насны хүүхдийн дархлаалжуулалтын хамралтын хувь 2014 онд 96.45%-тай байсан нь 2013 оноос 0.55%-иар буурчээ.

Зураг 21. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Сангийн яам

Эрүүл мэндийн үндэсний зарим хөтөлбөрүүдийн зардлыг бууруулна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, харуул хамгаалалтын зардал өндөр өсөлттэй байгаа бол эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүдийн зардлыг бүрэн хассан байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь үндсэн үйл ажиллагааны зардал 71%, тусгай зориулалтын шилжүүлэг 17.1% байна.


Зураг 22. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтээс харахад сүүлийн жилүүдэд эхийн эндэгдлийн түвшин буурсан боловч нялхас ба 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буураагүй байна (Зураг 23).


Зураг 23. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Дэлхийн банк

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж харьцангуй тэгш бус байгааг үр дүнгийн үзүүлэлтүүд аймаг тус бүрээр ялгаатай байгаагаас харж болно (Зураг 24). Тухайлбал, 1000 амьд төрөлтөд 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл Баян-Өлгий аймагт хамгийн өндөр буюу 31.4 байгаа бол Дундговь аймагт хамгийн бага буюу 10 байна.

Зураг 24. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд (аймаг, хот)



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, 2015 оны үзүүлэлт

Эмнэлгийн мэргэжилтний хүртээмж ялгаатай байна.

Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл эрүүл мэндийн уралдаан тэмцээн, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал өндөр өсөлттэй байгаа бол харуул, хамгаалалтын зардал, шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгох төлбөр буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 62.4%, үндсэн үйл ажиллагааны зардал 35.3% байна.


Зураг 25. Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



Эх сурвалж: Сангийн яам

Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтээс харахад 2015 онд 10000 хүн амд ноогдох эмнэлгийн мэргэжилтний тоо 156 орчим байгаа нь өмнөх онуудаас 1 мэргэжилтний тоогоор л өссөн үзүүлэлт байна.

Зураг 26. Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Сангийн яам

Хөдөө орон нутаг ба хотод эмнэлгийн ор ба эмнэлгийн мэргэжилтний тооны хүртээмж ялгаатай байна. Тухайлбал, 10000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаар 62.1, УБ хотод 83.2, хүний их эмч аймгийн дунджаар 22.6, УБ хотод 42.3, сувилагчийн тоо аймгийн дунджаар 33.1, УБ хотод 42.8, эмнэлгийн нийт ажиллагсдын тоо аймгийн дунджаар 136.2, УБ хотод 181.2, эмнэлгийн оронд ногдох хүний тоо аймгийн дунджаар 160.9, УБ хотод 120.1, нэг их эмчид ногдох хүний тоо аймгийн дунджаар 41.7, УБ хотод 36.5, жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо аймгийн дунджаар 4, УБ хотод 7.3 байна.

Хүснэгт 6. Хөдөө орон нутаг ба хот дахь эмнэлгийн ор ба эмнэлгийн мэргэжилтний тооны хүртээмж

Аймаг, хот	10000 хүн амд					Эмнэлгийн оронд ногдох хүний тоо	Нэг их эмчид ногдох хүний тоо	Жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо
	Эмнэлгийн орны тоо	Хүний их эмч	Сувилагч	Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтнууд	Бүх ажиллагсад			
Аймгийн дундаж	62.1	22.6	33.1	30.1	136.2	160.9	41.7	4
Улаанбаатар	83.2	42.3	42.8	17.9	181.2	120.1	36.5	7.3
Улсын дундаж	71.8	31.6	37.5	24.5	156.7	139.4	16.5	5.5

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, 2015 оны үзүүлэлт

Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагад хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин маш бага байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны төсвийн зарлагад хөрөнгийн зардал 5.2%-ийг эзэлж байна. Эрүүл мэндийн сайдын хөрөнгийн зардалд нийт 34.3 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 67.9% буюу 23.3 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 8.7% буюу 3 тэрбум төгрөг нь их засвар, 23.3% буюу 8 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна.

ЗУРГАА. БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 онд дээд боловсрол, насан туршийн албан бус боловсрол, боловсрол, ШУ-ны бодлого удирдлагын хөтөлбөрүүдийн урсгал зардлын хэмжээ буурна.


Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсөвт БСШУС-ын сайдын багц дахь боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрүүдийн нийт урсгал зардлын хэмжээг 1065.5 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад 1.4%-иар өсчээ.

Үүнээс сургуулийн өмнөх боловсрол 26.5%, ерөнхий боловсрол 56.9%, дээд боловсрол 11.5%, шинжлэх ухаан технологи 3.1%, насан туршийн болон албан бус боловсрол 0.3%, тусгай хэрэгцээт боловсрол 0.6%, боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага 1.2%-ийг тус тус зарцуулна.

Өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад дээд боловсролын хөтөлбөрийн урсгал зардал 22.8%-иар буурчээ.

Нийт боловсрол, ШУ-ны хөтөлбөрийн урсгал зардлыг төрлөөр нь авч үзвэл цалин, НДШ 3.6%, бараа үйлчилгээ 3.7%, татаас шилжүүлэг 83.2%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 27. 2017 оны БСШУС-ын сайдын багцын Боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрүүдийн урсгал зардал




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд бага зэрэг сайжирч байна.

Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд ерөнхийдөө сайжирч байгаа бөгөөд 2017 онд үзүүлэлтүүдийг илүү сайжруулах зорилт тавьсан байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүдийг авч үзвэл, нийт суралцах хүүхдийн тоо 2015 онд 211.7 мянга байсан бол 2017 онд 229.4 мянга, хүүхдийн цэцэрлэгийн тоо 2015 онд 1149 байсан бол 2017 онд 1371, хамран сургалтын хувь 2015 онд 82.9% байсан бол 2017 онд 86.8% болгож тус нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Харин төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог бууруулахаар тооцсон байна.

Зураг 28. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: БСНУС-ын яам, Сангийн яам


Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг өсгөнө.

Ерөнхий боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх, ЕБС-ийг сурах бичгээр хангах зардал тус тус өссөн бол дотуур байрны үйлчилгээ, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар

тооцжээ. Ерөнхий боловсролын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь тусгай зориулалтын шилжүүлэг (96.9%) байна.

Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдээс харахад сургуульд суралцагчдын тооны өсөлт нь зардлын өсөлтөд нөлөөлж байна. 2015 онд ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын нийт тоо 535.1 мянга байсан бол 2017 онд 559.2 болж нэмэгдэхээр байна.

Зураг 29. Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Эх сурвалж: БСШУС-ын яам, Сангийн яам

Дээд боловсролын салбарын үндэсний тэтгэлгийг бууруулна.

Дээд боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөр, орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг, оюутны сургалтын төлбөрийн зээлийн зардал тус тус өссөн бол үндэсний тэтгэлэг, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Дээд боловсролын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь оюутны сургалтын төлбөрийн зээл (73.5%) байна.


Зураг 30. Дээд боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



Эх сурвалж: БСШУС-ын яам, Сангийн яам

2017 онд Дээд боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтийг 2016 оны төлөвлөгөөтэй харьцуулахад буурахаар төлөвлөжээ. Тухайлбал, 2016 онд дэлхийн шилдэг сургуульд суралцагчдын тоог 265-аар төлөвлөж байсан бол 2017 онд 225-аар, багш, инженерийн чиглэлийн суралцагчдаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах суралцагчийн тоог 2016 онд 2209-өөр төлөвлөж байсан бол 2017 онд 1954-өөр тус тус төлөвлөсөн байна.

Зураг 31. Дээд боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд




Эх сурвалж: БСШУС-ын яам, Сангийн яам

Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь буурна.

Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардал тус тус өссөн бол ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь үндсэн үйл ажиллагааны зардал (61.9%), эрдэм шинжилгээ, судалгааны ажил (32%) байна.

Зураг 32. Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



Эх сурвалж: БСШУС-ын яам, Сангийн яам

Зураг 33. Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн үр дүнгийн зарим үзүүлэлтүүд



Бүх шатны боловсролын мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээ, боловсролын заавар, журам, гарын авлага бэлтгэх, хэвлүүлэх зардлыг өсгөнө.

Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл бүх шатны боловсролын мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээ, боловсролын заавар, журам, гарын авлага бэлтгэх, хэвлүүлэх зардал тус тус өссөн бол үндсэн үйл ажиллагаа, бусад зориулалт, арга хэмжээний зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь, үндсэн үйл ажиллагааны зардал 89.3% байна.

Зураг 34. Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



БСШУС-ын сайдын 2017 оны төсвийн зарлагад хөрөнгийн зардал 7.1%-ийг эзэлж байна. БСШУС-ын сайдын хөрөнгийн зардалд нийт 97.2 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 83% буюу 80.7 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 5.7% буюу 5.6 тэрбум төгрөг нь их засвар, 11.3% буюу 11 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна.

ДОЛОО. ТОЙМ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

2017 оны нэгдсэн төсвийн төслийн зарлагын төлөвлөлтөд хийсэн тойм судалгааны дүнг хураангуйлан дүгнэвэл:

Урсгал зардлын онцлог:

- Урсгал зардлын хэмжээ өмнөх оны эхний ба тодотгосон төсөвтэй харьцуулахад өсчээ.
- Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн түвшинг хадгалах зарчим баримтална гэсэн боловч нэмэгдэл цалин, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дүн өссөн дүнтэй байна.
- Бараа үйлчилгээний нийт зардлын дүн буурсан боловч зарим төрлийн бараа үйлчилгээний зардал өндөр өсөлттэй байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад эрс өсчээ.

Хөрөнгийн зардлын онцлог:

- Нийт зардлын өсөлтийг хязгаарлах зорилтыг хөрөнгийн зардлыг бууруулах замаар шийдвэрлэхийг оролдож байна.
- Барилга байгууламж, тоног төхөөрөжмийн зардлыг бууруулна.
- Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ буурна.
- Концессын хөрөнгө оруулалтыг төсөвт тусгах болсон.
- Хөрөнгө оруулалтын шинэ арга хэмжээ эхлүүлэхгүй байх зарчим баримтална гэсэн боловч шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг төсөвт тусгажээ.
- ҮАГ-ын дүгнэлтээр зөрчил бүхий хэд хэдэн төсөл, арга хэмжээг төсөвт тусгажээ.

Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагын онцлог:

- Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байна.
- Эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд зарцуулах нийт урсгал зардлын хэмжээ өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад бага зэрэг өснө.
- Нийт урсгал зардалд цалин хөлс ба боловсон хүчинтэй холбогдох зардал өндөр байна.
- Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарын үр дүнгийн үзүүлэлтүүд төдийлэн өндөр ахицтай биш байна.

БСШУС-ын төсвийн зарцуулалтын онцлог:

- БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад ойролцоо түвшинд байна.
- Нийт урсгал зардалд ерөнхий боловсролын хөтөлбөрийн зардлын эзлэх хувийн жин өндөр байгаа бөгөөд Ерөнхий боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал өснө.
- Дээд боловсрол, насан туршийн албан бус болосврол, боловсрол, ШУ-ны бодлого удирдлагын хөтөлбөрүүдийн урсгал зардлын хэмжээ буурна.
- Дээд боловсролын салбарын үр дүнгийн үзүүлэлтүүд төдийлэн өндөр ахицтай биш байна.
- Нийт урсгал зардалд татаас шилжүүлгийн эзлэх хувийн жин өндөр байна.
- Дээд боловсролын үндэсний тэтгэлгийн зардлыг бууруулна.
- БСУШС-ын сайдын багц дахь хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин бага байна.

Зөвлөмж:

Төсвийн зардалд тавих хяналтыг нэн тэргүүнд сайжруулах, өндөр өсөлттэй байгаа урсгал зардлуудыг дахин хянаж хязгаарлах, эрүүл мэнд, боловсролын салбарын

зардлын хуваарилалтыг сайжруулж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид төсвийн зардлын төлөвлөлтийг төсвийн орлогын өсөлтөөс ангид байлгах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын 2017 оны төсвийн төслийн баримт бичгүүд (төсвийн хуулийн төслүүд, төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга)
2. 2010-2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангууд
3. Үндэсний Аудитын Газар (2016). *Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт*
4. Дэлхийн банкны индикатор үзүүлэлтүүд
5. Эрүүл мэндийн яамны статистик мэдээлэл, тайлан
6. БСШУС-ын яамны статистик мэдээлэл, тайлан
7. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны мэдээллүүд
8. Бусад